



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/48

Номгон

Дэд станцын өргөтгөл шинэчлэлийн
ажлын барьцаа хөрөнгө
чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоол "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 2.9.1, 2.9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эрчим хүчний үндэсний төв төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 1/1196 дугаар албан бичиг, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 02/1570 дугаар албан бичиг, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 2024/34 дүгээр дүгнэлтийн дагуу 110/35/10 кв-ын Баянхонгор дэд станцын өргөтгөл, шинэчлэлийн ажлын чанарын баталгаа болох 664,832,775 (Зургаан зуун жаран дөрвөн сая найман зуун гучин хоёр мянга долоон зуун далан таван) төгрөгийг чөлөөлөхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй!

2.Дэд станцын хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт бодлого төлөвлөлтийн хэлтэс (Г.Энхбаяр)-т, үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

626010113